


БАТЛАВ:



МУИС-ИЙН СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ
ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР Д.ЗАЯАБААТАР

2025 оны 4 дүгээр сарын 17

“ЗОЧИН БАГШ” ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. МУИС-ийн 2025-2030 оны стратегийн тэргүүлэх чиглэл, зорилгуудын хүрээнд багшийн хичээлийн агуулга, арга зүйл баяжуулах, суралцагчийн шинжлэх ухааны онол, практикийн мэдлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Зочин багшийн хөтөлбөрийн хэрэгжүүлнэ.
- 1.2. Хөтөлбөрийн зорилго нь МУИС-ийн хөтөлбөрт тусгагдсан танхимын хичээл дээр тухайн шинжлэх ухааны чиглэлээр онол, практикийн мэдлэг, туршлагатай эрдэмтэн, судлаач, мэргэжилтнийг урьж лекц уншуулах, семинар, ярилцлага зохион байгуулах хэлбэрээр уг хичээлийн агуулга, арга зүйг баяжуулан, суралцахуйн үйл ажиллагааг дэмжихэд чиглэнэ.
- 1.3. МУИС-ийн Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төв “Зочин багш” хөтөлбөрийг хичээлийн жилийн улирал бүр зохион байгуулна.

Хоёр. Хөтөлбөрийн бүртгэл

- 2.1. “Зочин багш” хөтөлбөрт МУИС-ийн үндсэн орон тооны профессор багш хүсэлт гарган хамрагдах боломжтой.
- 2.2. Бакалавр, магистр, докторын сургалтын бүх ангиллын хичээлийн лекц эсвэл семинар дээр зочин багшийг урих боломжтой.
- 2.3. Зочин багш нь хичээлийн хуваарьт өдөр, цаг дээр танхимаар оролцох боломжтой байх ёстой.
- 2.4. “Зочин багш” хөтөлбөрийн бүртгэл хичээлийн жилийн улирал бүрийн I, II долоо хоногт зөвхөн цахимаар явагдана.
- 2.5. МУИС-ийн багш нь “Зочин багш” хөтөлбөрт хамрагдахдаа өөрийн зааж буй хичээл болон зочноор урих багшийн дэлгэрэнгүй мэдээллийг цахим бүртгэлд оруулж хүсэлт гаргана.
 - 2.5.1. Зочин багшийн овог, нэр, эрдмийн зэрэг, цол;
 - 2.5.2. Зочин багшийн иргэний бүртгэлийн дугаар болон дансны дугаар¹;
 - 2.5.3. Зочин багшийн заах хичээлийн сэдэв, агуулга, хэлбэр;
 - 2.5.4. Зочин багшийн заах хичээлийн түвшин, хуваарьт өдөр, цаг;

¹ Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд зочин багшийн цагийн хөлсийг тооцон олгох санхүүгийн зорилгоор ашиглана.

- 2.6. МУИС-ийн багшийг зочин багшаар урих бол өөрийн харьяалагдах тэнхимээс бусад тэнхим, салбар, бүрэлдэхүүн сургуулиас урьж болно.
- 2.7. МУИС-ийн багш тухайн хичээлийн жилийн нэг улиралд зөвхөн нэг удаагийн сургалтын 2 цагийн лекц эсвэл семинарын хичээлийг зочин багш урьж оруулах боломжтой.

Гурав. Зочин багшид тавигдах шаардлага

- 3.1. Зочин багш нь хичээл заах шинжлэх ухааны чиглэлээр боловсролын болон эрдмийн зэрэгтэй байхаас гадна доорх шаардлагыг хангасан байна.
 - 3.1.1. Суралцагчдад шинэ мэдлэг, мэдээлэл түгээх, зөв хандлага төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах мэдлэг, ур чадвартай байх;
 - 3.1.2. Тухайн мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- 3.2. Хичээлийн зочин багшаар уригдан ирэхээс өмнө тухайн хичээлийн хөтөлбөрийн агуулгатай танилцсан байна.
- 3.3. Академик байгууллагын соёл, хэм хэмжээ болон МУИС-ийн дотоод дүрэм, журмын хүрээнд лекц унших, семинар ярилцлага хөтлөн явуулна.

Дөрөв. Зочин багшийн хичээлийг зохион байгуулах

- 4.1. Хичээлийн хуваарьт өдөр, цаг дээр зочин багшийн хичээлийг зохион байгуулна.
- 4.2. Хөтөлбөрт хамрагдсан багш буюу урьсан багш хуваарьт хичээлийн цаг дээр зочин багшийн хамт хичээлийг удирдан явуулна.
- 4.3. Урьсан багш “Зочин багш” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд зориулан зочин багшийн хичээлийн явцыг баримтжуулна.
- 4.4. Урьсан багш болон зочин багш нь “Зочин багшийн бүртгэл” (Хавсралт 1) дээр гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Зочин багшийн цагийн хөлс

- 5.1. МУИС-ийн “Зочин багш” хөтөлбөрт хамрагдаж сургалтын 2 цагийн лекц эсвэл семинарын хичээл заасан зочин багшид сургалтын нэг цагийн хөлсийг дараах байдлаар тооцож хөлс олгоно.
 - 5.1.1. Докторын зэрэгтэй зочин багш - 100,000 төгрөг;
 - 5.1.2. Магистрын зэрэгтэй зочин багш - 75.000 төгрөг;
 - 5.1.3. Бакалаврын зэрэгтэй зочин багш - 50.000 төгрөг;
- 5.2. Зочин багшийн цагийн хөлсийг тухайн сарын төгсгөлд тооцож цахим бүртгэлд бүртгүүлсэн дансанд шилжүүлнэ.

Зургаа. Тайлан бэлтгэх


- 6.1. "Зочин багш" хөтөлбөрт хамрагдсан МУИС-ийн багш зочин багшийн хичээлийн тайланг бэлтгэнэ.
- 6.2. Тайланг дараах шаардлагын дагуу бэлтгэн Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төвийн faculty_development@num.edu.mn цахим шуудангийн хаягаар ирүүлнэ.
 - 6.2.1. Зочин багшийн заасан лекц, семинарын товч агуулга, мэдээлэл;
 - 6.2.2. Хичээл орж байх явцыг баримтжуулсан чанарын шаардлага хангахуйц 4-өөс доошгүй тооны зураг;
 - 6.2.3. Гарын үсгээр баталгаажуулсан "Зочин багшийн бүртгэл" (Хавсралт 1)

Хянасан:



Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих
төвийн эрхлэгч С.Отгонцэцэг

Боловсруулсан:



Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих
төвийн мэргэжилтэн Д.Мөнхбат

ЗОЧИН БАГШИЙН БҮРТГЭЛ

Зочин багш хөтөлбөрт хамрагдсан багшийн мэдээлэл бүртгэх хуудас		
1	Бүрэлдэхүүн/салбар сургууль	
2	Тэнхим	
3	Зочин багшийг урьж буй багшийн нэр, албан тушаал	
4	Хичээлийн нэр, индекс	
5	Хичээлийн хуваарь	
6	Хичээлийн хэлбэр	
7	Зочин багшийн нэр	
8	Зочин багшийн зэрэг, цол	
9	Зочин багшийн ажил, мэргэжил, судалгааны чиглэл	
10	Зочин багшийн орсон хичээлийн сэдэв	
11	Хичээлийн товч агуулга	
12	Хичээлд хамрагдсан суралцагчийн тоо	

Урьсан багш /нэр/
(гарын үсэг)

Зочин багш /нэр/
(гарын үсэг)